

**“МОНГОЛ ТӨМС” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2009.03.25

2008 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл	
1	Төслийн нэр	“Монгол төмс” хөтөлбөр	
2	Төслийн дугаар	7F-03747.02	
3	Санхүүжүүлэгч байгууллага	Швейцарийн хөгжлийн агентлаг	
4	Хөтөлбөр хэрэгжүүлж буй хугацаа	2008 – 2011 он	
5	Хөтөлбөрийн зорилго	Монголын төмсний салбарын бүтээмжийг сайжруулах замаар хэрэглэгчдийг дотоодын үйлдвэрлэлийн эрүүл, тэжээллэг хүнсний төмсөөр хангах, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах.	
6	Хөтөлбөрийн зорилтууд	<ol style="list-style-type: none"> <li>1. Үр үржүүлэг, үрийн хангалтын системийг хөгжүүлэх.</li> <li>2. Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах.</li> <li>3. Хүнсний тэжээллэг чанарыг сайжруулж, борлуулалтын сүлжээг боловсронгуй болгох.</li> <li>4. Бүх түвшинд чадавхийг бэхжүүлэх.</li> </ol>	
7	Төслийн үр шим хүртэгчид	<ul style="list-style-type: none"> <li>• Эрдэм шинжилгээний байгууллагууд</li> <li>• Лицензтэй албан үр үржүүлэгчид</li> <li>• Албан бус үр үржүүлэгчид</li> <li>• Хүнсний төмс тариалагч иргэн, ААН болон өрхийн тариалан эрхлэгчид</li> </ul>	
8	Зардал /2008-2011/	Төсөв/нийт шаардагдах зардал/	3872000.00 CHF
		Тухайн жилд төсөвлөсөн	1093586.82CHF
		Гүйцэтгэл /тухайн жилд/	771523.43 CHF
		Үүнд:	Зардлын нэр
		1.зоорь,хүлэмжний их засвар	211815,99
		2.тээврийн хэрэгсэлд	26501,21
		3.бусад машин тоног төхөөрөмж	41013,45
		4.бусад	77844,49
		5.цалингийн зардал	158937,56
		6.ашиглалтын зардал	39301,01
		7.үзүүлэнгийн талбай,сургалт,семинар	125545,97
		8.гадаад,дотоод зөвлөхийн зардал	23352,77
		9.байрны түрээс	3310,87
		10.гадаад, дотоод томилолт	50902,17
		11.эд хогшил худалдан авах	7944,25
		12.бусад	5053,69
		нийт	<b>771523,43</b>
	Санхүүгийн талаар:	Тайлангаас харахад: Төлөвлөсөн хэмжээнээс 322,1 мян.CHF буюу 29,5%-иар дутуу санхүүжилт хийгдсэн мэт харагдаж байгаа нь зарцуулагдах ажлууд нь он дамжиж хэрэгжиж байгаа, мөн санхүүжилт дараа жилийн 3 сард орж ирдэгтэй холбоотой юм. Зардлын 27.5%-ийг зоорь,хүлэмжний их засварт,16,3%-ийг үзүүлэх талбайд хийсэн сургалт, семинар зохион байгуулахад, 20,6%-ийг цалингийн зардал тус тус эзэлж байна. Хөтөлбөрийн Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтын 94%-ийг, хэрэгжүүлэгч	

			байгууллага болох МХШТФХ-ны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тайлант онд ямар ч санхүүжилт олгоогүй нь хөтөлбөрийн зарим арга хэмжээ тасрахад нөлөөлж байна. Хөтөлбөр нь : Санхүүжилт дутуу хийгдсэн ч хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг олгогдсон санхүүжилтын хэмжээгээр зохион байгуулсан байна.				
9	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлт% 82.6%	Дүн	93,2	89,5	88,0	60,0
		II шатны зорилт, арга хэмжээ	4	1	1	1	1
10	Хөтөлбөрийн хэрэгжилт		2008 оны хэрэгжилт-83.6%				
<p><b>1. Үр үржүүлэг, үрийн хангалтын системийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:</b>  <b>Үр дүн I-ийн хэрэгжилт: 93,2% (92+96+90+93+95)/5</b></p>							
	-Үр дүн 1.1 Эрүүл үрийн материал		<p><b>Үр дүн 1.1-ийн хүрээнд:</b> ЭШХ-үүд нь гэрээний дагуу Импала сортын-28000, Витара-43000, нийт- 71000 ш-ийг вирусээс эрүүлжигдсэн бэсрэг буцлуу үйлдвэрлэсэн бөгөөд 8800 ш –ийг аэропоник системд үйлдвэрлэжээ. 103.7м<sup>2</sup> талбай бүхий аэропоник системээр тоноглогдсон хүлэмжийг хамтран ажиллагч 2 хүрээлэн дээр угсарч ашиглалтад оруулсан. Үүний үр дүнд: 5180ш ургамаланцар болон тайрдас шилжүүлэн суулгах боломжтой болсон. Дулаалгатай аэропоник системийг ашигласнаар жилд 2 удаа тариалалт хийж, бичил буцлууны ургац авах боломж бүрдэж байна. <b>Хэрэгжилт-92%</b></p>				
	-Үр дүн 1.2 АҮҮ-ийн элит үр үйлдвэрлэл		<p><b>Үр дүн 1.2-ын хүрээнд:</b> 2008 онд хүрээлэнгүүд болон АҮҮ нар импала, витара сортын 25,7 тн супер супер элит, 28,1 тн супер элит, 32,8 тн элит үр /анхны элит үр/ үйлдвэрлэжээ. Голландын “Агрико” компаниас импортлосон 150тн санте сортын супер элит үрийг 6 компанид хуваарилан тариалуулж, 1201тн ургац авснаас 800тн элит үр нөөцөлжээ. Элит үрийн дундаж <b>24тн/га</b> байна. Энэ нь үр оройтож нийлүүлэгдсэн, хугацаа алдаж тариалснаас илүү их ургац авах бололцоог ашиглаж чадсангүй/зарим ААН-үүд үүнээс доогуур ургац хураасан/. Үндэсний зөвлөхүүд компаниудын үр үржүүлгийн талбай дээр: Сортуудыг гадаад байдлаар нь таних, сортын холио түүх, өвчний гадаад илрэлийг нүдлэн заазлалт хийх, талбайд химийн боловсруулалт хийх, хураалтын бэлтгэл, хураалтыг зохион байгуулах зэрэг зөвлөгөө өгсөн. Мөн ОУТТ-ийн мэргэжилтнээр зөвлөгөө өгүүлж, турилага судлуулсан. “Гацуурт” компанийн талбай дээр төмсний иш, навчийг химийн аргаар хагдраахад Реглон бодисыг хэрхэн ашиглах талаар өдөрлөг зохион байгуулсан нь үр дүнтэй ажил болсон. УГТСЭШХ-д “Вирусийн цэцэрлэг” байгуулсан бөгөөд АҮҮ, Үрийн хяналтын байцаагч нарын сургалтыг зохион байгуулсан. <b>Хэрэгжилт-96%</b></p>				
	-Үр дүн 1.3 АБҮҮ-ийн үр үйлдвэрлэл		<p><b>Үр дүн 1.3-ын хүрээнд:</b> 2008 онд үрийн төмсний нийт 185,5 га талбайд улсын хянан баталгаа хийсэн нь 2007 оноос 2,4 дахин, 2006 оноос 21,3 дахин өссөн үзүүлэлт юм. 185,5 га талбайн 80% гаруй нь сортын цэвэршилтээр I категорит, 9% нь II категорит, 8% нь III категорит орж байгаа нь сортын тариалангийн хувьд ихээхэн дэвшил гарсан үзүүлэлт юм. Тайлант онд</p>				

	<p>-Үр дүн 1.4 Орон нутгийн түвшинд үр түгээх</p> <p>-Үр дүн 1.5 Сорт сорилт, судалгаа</p>	<p>шинээр 84 АБҮҮ-ийг сонгосон.Нийт АБҮҮ нар нь 2008 онд:Импала сортыг 200,9 га-д, витара-109,7 га-д, санте-244,7 га-д тариалж, 3009,5 тн импала, 1638,9тн витара, 4566,1 тн санте сортын ургац буюу 16,6 тн/га авчээ.Баруун 5 аймгийн сургалтыг Ховдод хийсэн.Гэнэтийн цочир хүйтрэлт, мөндөр, шуурга, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор шуурхай мэдээллийн сүлжээ байгуулах ажлыг эхлүүлэхээр Дарханы УЦУОШГ-тай гэрээ хийж Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн 7 суманд урьдчилан мэдээлэх үйлчилгээ явуулахаар гэрээ байгуулж, шаардагдах санхүүжилтийг хийж эхлээд байна. <b>Хэрэгжилт-90%</b></p> <p><b>Үр дүн 1.4-ийн хүрээнд:</b> Шинээр сонгогдсон үр үржүүлэгчид, жижиг фермерүүдэд хөтөлбөрөөс шинэ сортуудын 178 тн үрийн төмснийг олгосон. Мөн Голландын “Агрико” компаниас төмсний үр шинэчлэлийг эрчимжүүлэх зорилгоор 150тн супер элит үр оруулж ирсэн бөгөөд усалгааны систем бүхий 5 компанид үржүүлжээ.Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Архангай, Өвөрхангай, Баянхонгор,Завхан, Говь-Алтай, Ховд аймгуудад шинээр сонгогдсон болон өмнө нь хамрагдсан фермерүүдэд сургалт зохион байгуулсан. Өрхийн аж ахуйг дэмжих зорилгоор 116 өрхөд 5 8тн үрийн төмс олгосон. Төмсний үр ариутгах 10ш багаж импортлон оруулж ирсэн бөгөөд уг багажийг төмсний суулгагчид угсрах юм. Энэ оны хувьд оройтож нийлүүлэгдсэн тул үр үржүүлэгч нарт хувиарлаад байна. ХААҮШУОНТ- тэй хамтран ажиллах гэрээ байгуулж 2007 онд Герман улсаас импортолсон 5 шинэ сортыг 5 аймгийн экстейншийн төвд тариалуулж, талбайн өдөрлөг зохион байгуулж, заавар,зөвлөгөө өгчээ. <b>Хэрэгжилт-93%</b></p> <p><b>Үр дүн 1.5-ын хүрээнд:</b> Голланд,Герман, Канад, Орос, Хятад улсын селекцийн 20 гаруй сортыг 4 цэгт нэгдсэн арга зүйн дагуу сорьж, ургац болон бусад үзүүлэлтээр нь шалгаруулах ажлыг үргэлжлүүлж байна. ”Агрико” компаниас авсан 6 шинэ сортын 80кг үрийг 2 цэгт туршин эхний үр дүнг гаргаад байна.Эдгээр сортууд нь эрт болон дунд эртийн болцтой, шинээр нь хүнсэнд хэрэглэх зориулалт бүхий сортууд юм. <b>2008 онд хөтөлбөрөөс нутагшуулсан шинэ сортуудыг / төмснийг/ 555,3 га-д тариалсан нь Улсын хэмжээнд тариалсан талбайн 4,5%-ийг эзэлж байна. 2007 онтой харьцуулахад тариалсан талбайн хэмжээ 2,6%, хураасан ургацын хэмжээ 1,5 дахин нэмэгджээ.</b> <b>Хэрэгжилт- 95%</b></p>
<p><b>2.Үйлдвэрлэлийн аргыг сайжруулах зорилтын хүрээнд:</b> <b>Үр дүн.2-ийн хэрэгжилт:88,0%</b></p>		
	<p>Үр дүн.2.1.Технологийг сайжруулах</p>	<p><b>Үр дүн 2.1-ийн хүрээнд:</b> Төмсний ургамлын нематод, дүгрэг хорхойн судалгааг эрдэмтэд, судлаачид, оюутнуудын оролцоотойгоор явуулын болон хээрийн судалгаа, лабораторийн шинжилгээг хослуулан хийсний үр дүнд: Борнуур сумын төмсний талбайгаас нематод, Сүмбэр, Шарын гол, Борнуур,Сант сумын хөрснөөс дүгрэг, Жаргалант,Шарын гол,Борнуур, Сант сумын төмсний талбайд 2зүйлийн бясаа, 4 зүйлийн бөөсийг</p>

	<p>Үр дүн.2.2.Үйлдвэрлэлийн аргыг сайжруулах</p>	<p>илрүүлжээ. Дүгрэг хорхойн эсрэг “Актара” бодисыг Монголд хэрэглэгдэх ургамал хамгааллын бодисын жагсаалтад батлуулсан. Кибберсиб, Бинорам, Биоялмаг, Биосил зэрэг био бордоо, бактофит, Битоксибацеллин зэрэг биоинсектицидийн бэлдмэлүүдийг талбайн нөхцөлд туршиж, хэрэглэх судалгааг явуулж байна. Голланд улсаас “Нью Кроп” ХХК-ийн оруулж, ашиглаж буй төмсний иж бүрдлийн техник технологийг сурталчлав. Говийн болон тал хээрийн бүсийн АБҮҮ-дэд 0,5 га-ийн бага оврын дуслын усалгааны систем би-ийг нийлүүлэв. <b>Хэрэгжилт-90%</b></p> <p><b>Үр дүн 2.2-ын хүрээнд:</b> Дуслын усалгаатай нөхцөлд шингэн бордоо хэрэглэх аргыг танилцуулах зорилгоор АБҮҮ-дэд зориулсан талбайн өдөрлөгийг Борнуур суманд зохион байгуулав. <b>Хэрэгжилт-86%</b></p>
<p><b>3.Борлуулалтын сүлжээг сайжруулах</b> <b>Үр дүн:3-ийн хэрэгжилт- 89,5%</b></p>		
	<p>Үр дүн3.1.Хүнсэн дэх төмсний үүрэг</p> <p>Үр дүн3.2. Борлуулалтын сүлжээг сайжруулах</p>	<p><b>Үр дүн 3.1-ийн хүрээнд:</b> УБ хотын 812 өрхийг хамруулсан судалгааг хийсэн.УМХГ-тай хамтран худалдааны төв, захуудад шалгалт хийж, гарал үүсэл нь тодорхойгүй төмсийг “Голланд” төмсний нэрээр борлуулж байсныг илрүүлж, телевизэд ярилцлага өгч Голланд, Герман сортуудыг сурталчлав. <b>Хэрэгжилт-85%</b></p> <p><b>Үр дүн 3.2-ийн хүрээнд:</b> Намрын ногоон өдрүүд, ГХЯ, СЯ, ХХААХҮЯ-дын нээлттэй хаалганы өдөр, дүүргүүдийн нээлттэй хаалганы өдрөөр амталгаат худалдаа болон шинэ сортуудыг сурталчилж, 1,5 тн төмсийг хэрэглэгчдэд борлуулав. 3 кг-ийн багтаамжтай 16000ш нийлэг уутыг таних тэмдэг, хаягтайгаар хийлгэж, төмс савлан худалдаалж байна. Зориулалтын дулаалга, хөргөлтийн систем бүхий 2,5 тн-ын даацтай бүхээгтэй ачааны машин, ОУТТ-ийн тусламжтайгаар төмс шаарах бага оврын машин тус тус худалдан авсан. 1000 тн-ын багтаамжтай үрийн төмс хадгалах механикжсан зоройг автомат тохируулга бүхий системээр тоноглож, ашиглалтад оруулав. <b>Хэрэгжилт-94%</b></p>
<p><b>4.Зохистой бодлого,нөхцөл</b> <b>Үр дүн:4-ийн хэрэгжилт- 60,0%</b></p>		
	<p>Үр дүн 4.1.Идэвхтэй удирдах зөвлөл</p> <p>Үр дүн 4.2.Тогтвортой МХШТФХ</p> <p>Үр дүн 4.3. Зээл орлогын боломж</p>	<p><b>Үр дүн 4.1-ийн хүрээнд:</b> Хөтөлбөрийн зохицуулах хороог 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр өргөтгөв. Үүнд: Төмс боловсруулах үйлдвэрийн болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах ОНБ-ын төлөөллийг оруулсан. <b>хэрэгжилт-90%</b></p> <p><b>Үр дүн 4.2-ын хүрээнд:</b> 2008 онд санхүүжилт төлөвлөгдөөгүй. Гэвч уг холбоо нь ХААҮШҮОНТ-тэй орон нутагт шинэ сортуудыг нэвтрүүлэх, хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. <b>Хэрэгжилт-20%</b></p> <p><b>Үр дүн 4.3-ын хүрээнд:</b> МХШТФХ-ны дэргэд Эргэлтийн санг үүсгэн зохион байгуулж, үйл ажиллагааны дүрэм, хөтөлбөрийг боловсруулаад байна. Фермерүүдээс буцаан төлөгдсөн хөрөнгө, санд үзүүлсэн бусад дэмжлэгүүд нь эргэлтийн сангийн хөрөнгийн эх үүсвэр болох бөгөөд 2008 оноос эхлэн фермерүүдэд олгогдсон багаж хэрэгсэл, бусад орцуудын эргэн төлөлт нь эргэлтийн санд орох юм. Эргэлтийн сангийн менежерийг сонгон шалгаруулахаар төлөвлөж байна. <b>Хэрэгжилт:70%</b></p>

11	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>-МУЗГ-аас хэрэгжүүлж буй “Атрын-III дахь аян” тариалангийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн анхны жил 2008 онд: Төмсний үйлдвэрлэл-28,5 мян.тн-оор, хүнсний ногооны үйлдвэрлэл-1,5 мян.тн-оор тус тус нэмэгдсэн. Монгол Улс дотоодын үйлдвэрлэлээр төмсний хэрэгцээгээ-100%, хүнсний ногооны хэрэгцээний 49%-ийг хангах боломжтой болсон.</p> <p>-2008 онд хөтөлбөрөөс нутагшуулсан шинэ сортууд болох импала, витара, санте төмсийг 555,3 га-д тариалсан нь Улсын хэмжээнд тариалсан талбайн 4,5%-ийг эзэлж байна. 2007 онтой харьцуулахад тариалсан талбайн хэмжээ 2,6%, хураасан ургацын хэмжээ 1,5 дахин нэмэгджээ. 1га-аас авах ургац 16,6 тн байгаа нь улсын дунджаас 5,2 тн/га-аар өндөр байна.</p> <p>-Халаалтын систем бүхий шилэн хүлэмжид угсарсан агропони системээс анх удаа 8800ш бэсрэг булцуу хурааж авсан нь дараагийн улирлаас эхлэн агропони системээс 2 дахин ургац авах боломжтойг харуулж байна.Монгол Улс энэхүү дэвшилтэт аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр Азид эхний тавд багтаж байгаа юм.</p> <p>-2008 онд үрийн төмсний нийт 185,5 га талбайд улсын хянан баталгаа хийсэн нь 2007 оноос 2,4 дахин, 2006 оноос 21,3 дахин өссөн үзүүлэлт юм.<b>185,5 га талбайн 80% гаруй нь сортын цэвэршилтээр I категори, 9% нь II категори, 8% нь III категори орж байгаа нь сортын тариалангийн хувьд ихээхэн дэвшил гарсан үзүүлэлт юм.</b></p> <p>2-р үе шатанд хөтөлбөрийн зорилтын арга хэмжээнүүдийн хэрэгжилт 2008 оны жилийн эцсийн байдлаар: Дунджаар 82.6% буюу “Хангалттай” гэсэн үнэлгээг өгч байна.</p> <p><b>Дутагдал:</b></p> <p>-2008 онд шинэ сортуудын дундаж өмнөх оноос 1,9 тн/га-аар буурч 16,6 тн/га болсон нь 2004 онд анх орж ирсэн үрийн чанар муудаж, сортын удамилын доройтолд орж байгаатай холбон тайлбарлаж байгаа бөгөөд үр үйлдвэрлэгчдийн үрийн шинэчлэл хийх шаардлагатай гэж үзэж байна.</p> <p>-Зах зээлийн системийн доголдоос болж хэрэглэгчдийн гар дээр бүтээгдэхүүний үнэ 2 дахин өсөж очиж байна.Үүнд: Өөрсдийгөө “Ченж” гэж нэрлэсэн хэсэг бүлэг хүмүүсийн үйл ажиллагаа ихээхэн нөлөөтэйг тэмдэглэх нь зүйтэй.</p> <p>-Судалгаанд хамтран оролцож буй фермерүүдийн ихэнх нь төмсний өвчин,хортны талаар суурь мэдлэг муутайгаас мэдээллийг хүлээн авах, боловсруулах, хэрэгжүүлэх чадвар сул байна.</p>
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ	<p>Хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна.</p> <p>МХШТФХ-ны үйл ажиллагааг Тогтвортой явуулахад үйл ажиллагааны зардалд санхүүжилтыг тусгаж өгөх нь зүйтэй.</p>
13	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өгөх зөвлөмж	<p>1.Судалгаанд оролцох фермерүүдэд ажиглалт, судалгаа, туршилтын ажлын арга зүй эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах.</p> <p>2.Орон нутгийн нөхцөлд төмсний зоорь барихдаа</p>

	<p><i>стандартын шаардлагыг хангах, дулаалга болон салхилуулалтын төхөөрөмжөөр тоноглох.</i></p> <p><i>3. Үр үйлдвэрлэгчдийн үрийн шинэчлэлийг сайжруулах.</i></p> <p><i>4. Төмсний үйлдвэрлэлийг хөдөө орон нутагт тасралтгүй нэмэгдүүлэх, зах зээлийн нөхцөлийг сайжруулах, шинэ технологийг алслагдсан бус нутгуудад хөгжүүлэх.</i></p> <p><i>5. Санхүүжилтыг төлөвлөсөн хэмжээнд зарцуулах.</i></p>
--	---

CHF-Швейцарь франк

МХШТФХ-Монголын Хөдөөг Шинэчлэхийн Төлөө Фермерүүдийн Холбоо

АҮҮ-Албан үр үржүүлэгч

АБҮҮ-Албан бус үр үржүүлэгч

Танилцсан: МХШҮГ-ын дарга

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн: Мэргэжилтэн

Л.Баяртулга

С.Сонгууль